

XX ЗУУНЫ МОНГОЛ ОРОНД ӨРНӨСӨН АТРЫН АЯНУУД, ТҮҮНИЙ ОНЦЛОГ

Б.ПУНСАЛДУЛАМ

Товч агуулга: Монгол улсын түүхэнд атрын гурван удаагийн аян өрнөж байснаас эхний хоёр нь XX зуунд явагджээ. Атрын анхны аян 1959-1961 онуудад өрнөсөн байна. Энэ он жилүүд буюу 1954-1960 он бол БНМАУ-ын УААА-н бүх салбарт социалист үйлдвэрлэлийн харилцааг бүрэн ялуулж, эдийн засгийн суурь үндсийг тавьсан он жилүүдэд байв. Тус улсад социализмыг дэлгэрэнгүй байгуулах зорилтыг 1954 оны 11 сард хуралдсан МАХН-ын XII их хурлаас дэвшүүлсэн байна. 1954 оны зургаадугаар сарын 13-нд АИХ-ын шинэ сонгууль болж, бүх сонгогчид нам ба нам бусчуудын эвслээс нэр дэвшигчдийн төлөө саналаа өгч, МАХН дангаараа ялсан байна. 1954 оны долдугаар сард АИХ-ийн сонгуулийн хоёр дахь удаагийн Анхдугаар чуулган АИХ-ын Тэргүүлэгчдийн даргаар Ж.Самбууг сонгож, Ю.Цэдэнбал тэргүүдтэй Засгийн газар байгуулагджээ. Энэ нь социализм байгуулах үндсэн зорилтыг шийдвэрлэхийн тулд улс орны нийгэм улс төрийн тогтолцоо, төрийн засаглал, хяналт, гүйцэтгэлийг бүгдийг нэг удирдлагад төвлөрүүлсэн хэрэг байв. Энэ цаг үеэс МАХН-ын дангаар ноёрхох оргил цаг эхэлж, өөрчлөлт шинэчлэл, ардчилалын үеийг хүртэл үргэлжилжээ. Өөрөөр хэлбэл, социализм байгуулах үндсэн зорилтыг шийдвэрлэхийн тулд нэг удирдлага, хүчтэй засаглал байх ёстой хэмээн төрийн засаглал, хяналт, гүйцэтгэлийг бүгдийг намд төвлөрүүлж төржсөн намын систем тогтсон байна.

Түлхүүр үг: XX зуун, Монгол орон, МАХН, Атрын аян, социалист үйлдвэрлэлийн харилцаа

МАХН, УААА-н бүх салбарт социалист үйлдвэрлэлийн харилцааг бүрэн ялуулах зорилтыг хэрэгжүүлэхийн тулд УААА, соёлыг хөгжүүлэх таван жилийн төлөвлөгөөг түр завсарлаж, гурван жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлжээ. БНМАУ-ын УААА, соёлыг хөгжүүлэх 1958-1960 оны гурван жилийн төлөвлөгөөний хүрээнд

1. МАА-г хөгжүүлж, ардын аж ахуйтныг аажмаар сайн дурын үндсэн хоршооллох
2. ХАА-г социалист ёсоор хөгжүүлэх зорилтын хүрээнд Монгол оронд атар газрыг хагалж, газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх
3. Аж үйлдвэр, тээвэр холбоо, их барилгажилтыг орнүүлэх

4. Соёлын довтолгооныг зохион байгуулсан байна. Эдгээр зорилтод хөтөлбөрүүд өөр хоорондоо уялдаа холбоо бүхий нэгдсэн удирдлага, зохион байгуулалтын дор өрнөж, ЗХУ болон бусад социалист улс орнуудын дэмжлэг тусламжаар өмнөө тавьсан зорилтоо хэрэгжүүлсэн байна.

Гурван жилийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан гадаад шалтгаан нь тухайн үед хуралдсан ЗХУ-ын ЗХУКН-ын XXI их хурал хуралдаж, коммунист нийгмийг өрнүүн байгуулах том зорилт дэвшүүлж, улмаар ЗХУ-ын 7 жилийн төлөвлөгөө (1959-1965) социалист лагерийг улам бүр бэхжүүлж, социалист лагерийн бүх орон, коммунизмд бараг нэг зэрэг шилжин орох болно хэмээн заасан явдал байв. Өөрөөр хэлбэл, ЗХУ, ЗХУКН-ын гадаад улс төрийн бодлого байсан юм. Харин үүнийг улам идэвхжүүлсэн зүйл нь 1957, 1960 оны Москвагийн тунхагууд байв. Тухайн үед дэлхий дахин хоёр системд хуваагдаж, социалист системийн улс орнуудын хүчин чадал өсөхийн хэрээр олон улсын хөгжил, улс төрийн харилцаанд үзүүлэх нөлөө нэмэгдэх болов. Социалист орнуудын эдийн засгийн хөгжлийн хурд нэмэгдэж улмаар 1957-1960 онд аж үйлдвэрийн бүтээгдхүүний хэмжээ 37,1 хувиар өссөн байхад, капиталист орнуудынх 7,4 хувьтай байв. Эгнээндээ 12 улсыг нэгтгэсэн энэ системийн улс орнууд сансар огторгуйг эзэмших тал дээр ч тэргүүлж байв.

УААА, соёлын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулахад хүргэсэн дотоод хүчин зүйл нь тус оронд хөдөө аж ахуйг социалист ёсоор өөрчлөн байгуулах буюу ардын хувийн аж ахуйтныг хоршооллож нэгдэлжүүлэх ажил үндсэндээ дууссан явдал байв. Түүнчлэн ЗХУ-ын тусламж дэмжлэгтэйгээр аж үйлдвэр, тээвэр холбоо, улс хоршооллын худалдааны байгууллагууд хөгжиж социалист өмч харилцаа бэхжсэн хэрэг байв. Нэг ёсондоо социалист үйлдвэрлэлийн харилцаа ялж, социализмын материал техникийн баазыг байгуулах суурь үндэс бүрджээ хэмээн үзэж байсанд оршино. МАХН-ын ТХ-ны тогтоолд өөрчлөлт оруулах шалтгаанаа

1-д.1958 он гэхэд ардын аж ахуйтныг хоршоолж үндсэндээ дууссан тул социалист харилцаа тогтсон.

2-д.1958 оны улсын төлөвлөгөөг амжилттай биелүүлснийг тэмдэглээд, нэмэлт засваруудыг 3 жилийн төлөвлөгөөний төсөлд оруулжээ.

Ийнхүү УААА, соёлыг хөгжүүлэх 1958-1960 оны 3 жилийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулснаар 1961 оны ургацаас эхлэн тус орны гурилын хэрэгцээг өөрийн үйлдвэрээр хангахын тулд 1959-1961 онд 300 мянган га атар газар эзэмших зорилт хэрэгжүүлэх их ажил өрнөж атрын анхны аян өрнөх үндэс тавигдсан байна.

Өөрчлөлт оруулсан төлөвлөгөө ёсоор атар газар эзэмших, тариаланг хөгжүүлэх ажлыг юуны өмнө САА-нууд хийх ёстойг заасны дагуу хуучин САА-нуудын тариалангийн талбайг өргөтгөхийн хамт Хөвсгөл, Чойбалсан, Төв аймаг, Сүхбаатар хотын хавь нутагт 1959 онд үр тарианы чиглэлийн дөрвөн (Дархан, Зэлтэр, Эг-үүр, Хэрлэн) САА шинээр байгуулахаар заажээ. Ийнхүү МАХН-ын XII их хурлаас дэвшүүлсэн улс орныхоо хэрэгцээг гурилын 50 хүртэл хувийг дотооддоо үйлдвэрлэх зорилтыг хэрэгжүүлэх үүднээс атрын аянг кампанит ажил болгон өрнүүлжээ.

Тариалангийн талаар тавигдаж буй энэ том программыг биелүүлэхдээ ХАА-н социалист секторыг түшиглэнэ. Энэ социалист сектор нь САА (Сангийн аж ахуй), МААМС (Мал аж ахуйн машинт станц), ӨХМС (Өвс хадах морин станц), ХААН (Хөдөө аж ахуйн нэгдэл)-үүд бөгөөд тэдгээрийн аж ахуй зохион байгуулалтын талаар бэхжүүлэх асуудлыг анхаарахын зэрэгцээ 1958-1960 онд тариалангийн талбайн 80-90 хувийг социалист секторын мэдэлд төвлөрүүлэх зорилт тавьсан байна. САА, станцуудыг бэхжүүлэх, тэдгээрийн ажлыг олон талтай болгон өргөтгөх хэрэгт ЗХУ-ын үзүүлэх сэтгэл харамгүй тусламж шийдвэрлэх ач холбогдолтой байна. Энэ тусламжийн ачаар 1958-1960 онд МААМС, ӨХМС-дад чиргүүл бүрэн багажтай янз бүрийн маркийн 580 трактор, 300 комбайн төрөл бүрийн маркийн ачааны 2000 автомашин, 65 цахилгаан хөрөө, уурын ба дизелийн 200 цахилгаан станц, нэг загварын 600 байшин, САА-д зориулж 400 гаруй трактор, 380 комбайн төрөл бүрийн ачааны 1000 авто машин зэрэг техникийг өөрийн хөрөнгөөр худалдан авч хангахад наад зах нь 10 жил хэрэгтэй болохыг тэмдэглэжээ.¹

МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл 1959 оны 2 дугаар сард “1959-1960 онд тариаланг эрс нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай” чухал тогтоолыг хамтран гаргасан байна. Үүнээс нэг сарын дараа буюу 3 дугаар сард хуралдсан МАХН-ын Төв Хорооны III бүгд хурлаас 1959-1961 онд атар газар эзэмших замаар газар тариаланг хөгжүүлэх зорилтыг дэвшүүлж “тус орны гурилын хэрэгцээг өөрийн орны бүтээгдэхүүнээр хангах, мал аж ахуйн тэжээлийн баазыг бэхжүүлэх тухай” тогтоолыг гаргаж “Атрын анхны аян” өрнөсөн байна. Энэхүү шийдвэрийг хэрэгжүүлж хуучин САА-нуудын тариалангийн талбайг өргөтгөх, техник хангамжийг сайжруулахын хамт шинээр Дархан, Зэлтэр, Хэрлэн, Эгүүр гэсэн дөрвөн САА-г атрын анхны жил буюу 1959 онд байгуулж, 1959-1961

¹ МАХН-ын Их хурал, ТХ-ны бүгд хурлуудын тогтоол шийдвэр. III хэсэг. 1957-1962. Улаанбаатар: 1963, 37.

онд 300.0 мянган га атар газар эзэмшиж хэрэгцээт гурилыг дотооддоо үйлдвэрлэх хэмжээний үр тариаг тариалах тодорхой зорилт дэвшүүлжээ. Ийнхүү МАХН-ын XII их хурлаас дэвшүүлсэн улс орныхоо хэрэгцээт гурилын 50 хүртэл хувийг дотооддоо үйлдвэрлэх зорилтыг хэрэгжүүлэх үүднээс атрын аянг кампанит ажил болгон өрнүүлж 1959 оны санхүүжилтийн дүн болох 436 сая төгрөгнөөс зөвхөн тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд зориулж 40 сая төгрөгийг зориулжээ.

Монгол оронд атар газар хагалаж, тариалангийн үйлдвэрлэл хөгжүүлэх анхны программыг хэрэгжүүлэхэд тус улсын тариалж болох талбайг гүйцэд судлаагүй, орчин үеийн машинтехникийн хүрэлцээ хангамж муу, инженертехникийн боловсон хүчний дутагдалтай, газар тариалангийн томоохон үйлдвэрлэлийг эрхлэн хөтлөх дадлага туршлага бага зэрэг бодит бэрхшээл тулгарч байв. Тиймээс атар газар эзэмших анхны аян, шинээр газар хагалах, шинээр суурин төвөө босгох, техник эзэмших, ашиглах, залуусаа амьдралд сургах, тариалангийн агротехникийн арга ухаанд суралцуулах гээд олон төрлийн ажил нэг дор зэрэг эхлэн явагдсан байна. Амжилт хэдий их байсан ч ажлын туршлага дутмаг, төлөвлөгөө нормын хойноос хэт хөөцөлдөх явдал багагүй байжээ. Атарчидад тохилдож байсан хамгийн гол бэрхшээл нь техникийн мэдлэг чадвар муу, бүрэн дүүрэн ашиглаж чаддаггүй, засвар үйлчилгээ хийж мэдэхгүй зэргээс болж байв. Монгол орны аж үйлдвэр, барилга, тээвэр, холбоо, газар тариалангийн үйлдвэрлэлийн техник хангамж эрс өсөн нэмэгдэхийн хирээр мэргэжилтэй ажилтан дутагдаж байв. Өөрөөр хэлбэл, трактор комбайн байсан боловч түүнийг эзэмших, ажиллуулах хүн цөөхөн байв.

Атар газар эзэмших анхны аяныг өрнүүлэхдээ, хуучин САА-дын хөдөө аж ахуйн мэргэжилтнүүдийг шинээр байгуулсан САА-дад шилжүүлэн ажиллуулахыг урьтал болгосонгүй, харин шинэ залуусыг сургаж авахыг зорьж байв. Энэ ажилд Зөвлөлтийн мэргэжилтнүүд атар газар хагалах, тариалах, хураах их ажлыг гүйцэтгэхийн хажуугаар монгол залуусыг сургах үүргийг хүлээж байсан тул шинээр байгуулагдсан үр тарианы чиглэлийн нэг САА-нуудад 20-иос дээш тооны мэргэжилтнүүд ажиллаж байв. Зөвлөлтийн мэргэжилтнүүд шинээр байгуулагдсан САА-даас гадна бусад хуучин байсан САА, МААМС, ХААН-үүдэд ажиллаж олон арван залуусыг сургаж байв. Үүний үр дүнд анхны атарчид хэмээх нэр томъёо Монголын XX зууны газар тариалангийн хөгжлийн түүхэнд 1950-иад оны сүүл, 1960-аад оны эхээр гарч ирсэн бөгөөд энэ нь шинээр тариаланч, механикжуулагч нар үүсч буй хэрэг биш харин атар газар эзэмших аяныг төрөөс улс орон даяар зохион байгуулж, зохих амжилтад хүрсний илэрхийлэл юм. Өөрөөр хэлбэл Монголын тариаланч, механикжуулагчид атрын аяныхнаар эгнээгээ өргөтгөж,

ХАА-н мэргэжилтэй механикжуулагчдын тоо өсөн нэмэгдэж, Монголын нийгэмд тариаланч, механикжуулагчдын бүлэг бодитойгоор оршин тогтнож, нийгэм, эдийн засгийн хөгжилд зохих хувь нэмрийг оруулах болжээ.

Атар газар эзэмшсэнээр ажилчин анги, хөдөлмөрийн сэхээтний эгнээ газар тариалангийн механикжуулагч, инженер техникийн ажилчдаар өргөжиж хөдөөгийн төдийгүй улсын хүн амын нийгмийн бүтцэд том өөрчлөлт гарчээ. Тухайлбал, хүн амын 41,3% ажилчин анги, 36,6% хоршооллосон ард, 21,8% албан хаагчид эзлэх болжээ².

Статистикийн тоо баримтаар харуулбал: УААА-н гол салбарт ажиллаж байгаа ажилтан, албан хаагчдын дундаж тоо (мянган хүн)

	Ажилчин албан хаагчид	Үүнээс				
		аж үйлдвэрт	их барилгад	ХАА-д	Тээвэр холбоо	худалдаа
1950	62,8	23,7	1,7	7,8	2,8	5,0
1955	101,3	18,0	7,3	16,1	4,0	13,0
1960	144,6	35,3	19,3	20,4	15,4	14,7
1961	152,5	36,4	21,3	19,6	13,9	17,5
1962	160,3	37,7	20,6	22,3	16,6	16,8
1963	196,9	37,7	19,4	24,0	16,6	21,8
1964	1967,7	37,8	15,1	22,0	17,2	20,7
1965	173,2	39,9	13,6	22,8	17,5	22,6
1966	183,5	43,9	14,5	22,6	17,5	24,0

Эх сурвалж: БНМАУ-ын УААА 1967 онд
Статистикийн эмхтгэл. УБ., 1968. т.50

1961 онд УААА-н салбарт ажиллаж байгаа ажилтан албан хаагчдын тоо 152,5 мянган хүн, түүнээс ХАА-н салбарт 19,6 мянган хүн ажиллаж байсан бол, 1966 онд УААА-д нийт 183,5 мянган ажилчин, албан хаагч ажиллаж байснаас ХАА-н салбарт 22,6 мянга нь ажиллах болж нэмэгдсэн байна. 1961 оны байдлаар САА-дад 11,5 мянган ажилчид ажиллаж байжээ³.

Монголд анхны атрын аяныг зохион байгуулахад хүн хүч, техник, мэргэжилтэй ажилчны хүрэлцээ хангамж, орон байр, мөнгө хөрөнгө санхүү зэрэг олон талын бэрхшээл байсан боловч гол нь олон мянган жил мал маллаж байгаль дэлхийгээ хайрлан, уул усаа тахин шүтэж ирсэн монголчуудын сэтгэл зүйг давах нь хамгийн хэцүү байсан тухай САА-н удирдах газрын дарга, ХААЯ-ны орлогч сайд асан

² БНМАУ-ын нийгмийн бүтэц. Улаанбаатар: 1984, 95.

³ МАХН-ын XIV их хурал. Дэлгэрэнгүй тайлан. Улаанбаатар: УХХЭХ, 1961, 38.

Ц.Лоохууз гуай дурсжээ. Тэрээр “Манай монголчууд газар хагалахад угаасаа дургүй шүү дээ. Газар хагалж тариа тарьна гэдэг бол юуны өмнө малын бэлчээрийг сүйтгэж байгаа хэрэг юм шүү дээ. Нөгөө талаар газар хагалж, тариа тарина гэдэг бол ядуу хүний ажил. Амьдрах өөр арга байхгүй хүмүүс өлбөрч үхэхгүйн тулд газар хагалж тариа тарьж, түүнийгээ идэж амьдарч байгаа юм гэсэн уламжлалт монгол сэтгэлгээ байдаг юм. Монгол хүний толгойд хэдэн мянган жил оршсоор ирсэн энэ үзэл санааг давж гарах маш хэцүү байсан юм аа. Энэ үзэл санааг давж гарахад орчин үеийн хүчирхэг техник, шинжлэх ухаан хоёр л тусалсан. Өөр юу ч туслаж чадахгүй байсан гэж би боддог юм” хэмээн ярилцлага өгсөн байдаг.

Атрын анхны аяныг өрнүүлсэн гурван жилийн төлөвлөгөөний жилүүдэд САА-д газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар түүхэндээ анх удаа том үсрэлт хийж тариалангийн нийт талбай 204 мянган га-д хүрч 1957 оныхоос 4 дахин өсжээ. Үүнд улаан буудайн талбай 6 дахин, төмс ногооны талбай 44,9% малын тэжээлийн талбай 5,6 дахин нэмэгдсэн байна. Тариалангийн талбай жил тутам дунджаар 50 гаруй мянган га-газар, ялангуяа 1960 онд 80000 шахам га-гаар өссөн төдийгүй, 3 жилд га тутмаас авах ургацын хэмжээ нэмэгдсэн байна. 1960 онд га дутмаас дунджаар улаан буудай 12,2цн, төмс 108цн, хүнсний ногоо 205,9 цн авч 1957 оны байдлаас улаан буудайн ургацыг 52,5%, төмсний ургацыг 37,2%, хүнсний ногооны ургацыг 2 дахин нэмэгдүүлжээ. Улсын сангийн аж ахуйнууд 1960 онд 1 га-гаас 12 цн үр тариа авах үүргээ нэр төртэй биелүүлсэн байна. 1959 онд байгуулагдсан Дархан, Зэлтэр, Хэрлэн зэрэг атрын САА-нууд 1960 онд га тутмаас 12-13цн улаан буудай авч, хураасан талбайн га тутмаас 7-10 цн бүтээгдхүүнийг улсад тушаасан нь 1960 онд бүх аж ахуйгаас улсад тушаасан буудайн 25 хувийг эзэлж байв. Атрын САА-дын 1 цн үр тарианы өөрийн өртөг улсын дунджаас 20-30 хувь доогуур байгаа нь Монгол орон даяар өрнөсөн атрын аяны эдийн засгийн ач холбогдлыг харуулжээ. Атрын аяны үр дүнд газар тариалан ХАА-н бие даасан салбар болон хөгжиж, эх орныхоо гурил, малын тэжээлийн дотоодын хэрэгцээг хангаад зогсохгүй хүнсний үйлдвэрүүд цоо шинээр хөгжих суурь тавигдаж, хөдөөд онгон зэлүүд байсан газарт олон арван тосгон, суурингууд бий болж, ахуйн болон техникийн соёл өргөн нэвтэрч, хөдөөгийн нүүр царайг өөрчилсөн нийгмийн том ач холбогдолтой арга хэмжээ болжээ.

Монгол оронд өрнөсөн эхний хоёр атрын аяныг МАХН удирдан чиглүүж, МХЗЭ зохион байгуулж, идэвхжүүлж, уриалж, улсын өмчийн САА, ТАА, ХААН-үүд тариалангийн үйлдвэрлэлийг голлон хариуцсан байна. Энэ нь Монгол оронд өрнөсөн эхний хоёр атрын аяны ижил талууд болно Түүнчлэн атрын аянууд, ЗХУ-

ын техник, эдийн засгийн тусламжтайгаар хэрэгжсэн бөгөөд, атрын анхны аянд Зөвлөлтийн мэргэжилтнүүдийн хүч оролцоо шийдвэрлэх үүрэгтэй байсан бол, хоёр дугаар аяны гол хөдөлгөгч хүч нь Монголын үндэсний мэргэжилтэй боловсон хүчнүүд голлох үүрэгтэй байжээ. Атрын анхны аяны үед, 1959 оны 2-сарын 20-нд “ЗСБНХУ-аас БНМАУ-д атар газар эзэмшихэд болон геологи хайгуулын ажил явуулахад тусламж үзүүлэх тухай” хэлэлцээр байгуулж, түүний нэгдүгээр зүйлд, үр тарианы асуудлыг шийдвэрлэх ба атар газрыг эзэмшихэд ЗСБНХУ-аас БНМАУ-д техникийн тусламж үзүүлэхийн тулд энэ оны (1959) I улиралд инженер механикжуулагч 21, тракторын бригадын дарга механикч 60, трактор комбайнч 200, барилга инженер 5, түүнчлэн ЗСБНХУ-ын атар газар дахь улсын САА-н удирдах ажлын туршлагатай ХАА-н 21 мэргэжилтнийг БНМАУ-ын САА-н зөвлөгчөөр 2 жил хүртэл хугацаагаар нийлүүлнэ⁴ хэмээн үүрэг хүлээснээр, Зөвлөлтийн мэргэжилтнүүд атрын аяны хоёр жилд Монголд оршин сууж, өдөр тутмын ажлын хажуугаар монгол залуусыг сургаж, хүмүүжүүлэх их ажлыг гүйцэтгэжээ. Тиймээс ч атрын анхны аяны хүрээнд Монголд ирж ажилласан Зөвлөлтийн олон мэргэжилтнүүд БНМАУ-ын төрийн дээд одон медалиар шагнагдсан байна. Үүнд, шинээр байгуулагдсан Дарханы САА-д ажиллаж байсан Зөвлөлтийн мэргэжилтэн Гусаков Леонорд Григорьевич, Зэлтэрийн САА-н мэргэжилтэн Кравченко Алексей Михайлович нар Сүхбаатарын одонгоор, Дарханы САА-н тракторч Скориков Андрей Степанович, мөн аж ахуйн бригадын механикч Денисов Михайл Андреевич, Зэлтэрийн САА-н инженер Горбуков Николай Сергеевич, Хэрлэнгийн САА-н бригадын механикч Гусев Семон Николаевич нарыг Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одонгоор шагнагдсан байна.

Хоёрдугаар аяны үед, ургац хураалтын үеэр цөөн тооны мэргэжилтнүүд өөрсдийн комбайн техник хэрэгсэлтэй ирж ажилд туслалцаж байв. Түүнчлэн техник, засвар үйлчилгэний инженер мэргэжилтнүүд ирж ажиллаж байв. Тиймээс Зөвлөлтөөс ирж ажилласан мэргэжилтнүүдийг тухайн САА-н даргын тушаалаар урамшуулан шагнаж байв. Тухайлбал, Хэнтий аймгийн Чандганы САА-н дарга Д.Гомбожавын 1982 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн №181. “Зөвлөлтийн комбайнчдыг шагнах тухай” тушаал гаргаж, тус САА-д Чита мужаас ирж ажилласан 8 комбайчин тус бүрт 20 төгрөгийн үнэ бүхий зүйлээр урамшуулж, шагнал нийтдээ 173 төгрөг 60 мөнгийг зарлагджээ. Баримтаас харвал, 1982 онд Чандганы САА-д Зөвлөлтийн Чита мужаас 8 комбайнч ирж ажилласнаас гадна

⁴ *Монгол-Зөвлөлтийн харилцаа 1921-1974. Хоёрдугаар боть. Нэгдүгээр хэсэг. Улаанбаатар: 1981, 475-476.*

намрын тариа хураалтын үеэр техник засвар, үйлчилгээг хариуцсан мастер тохируулагч гурван мэргэжилтэн урьж ажилуулсан байна. САА-н даргын 1982 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн № 190 тоот тушаалд, тариа хураалтын үеэр үзлэг засварын ажлыг шуурхай хийж амжилт гаргасан мастер тохируулагч гурван хүнд тус бүрт нь 38 төгрөгийн үнэ бүхий зүйлээр урамшуулан /шаазан гутал-3ш үнэ тус бүрийн 13 төгрөг, савхийн бээлий 3ш, тус бүрийн үнэ 25 төгрөг/ нийт 114 төгрөгийн зарлага гаргажээ⁵.

Атрын анхдугаар аян, социалист харилцааг УААА-н бүх салаа мөчирт тогтоох зорилтын хүрээнд хэрэгжсэн бол, ХХ зууны 70-аад оны дунд үед өрнөсөн атрын хоёрдугаар аян, социалист бүтээн байгуулалтын он жилүүдэд өрнөжээ. Энэ үед УААА, тэр дундаа ХАА-н салбарт оруулах хөрөнгө оруулалт эрс нэмэгдэж, материал техникийн болон мэргэжилтэй үндэсний боловсон хүчнээр улс орон хангагдсан байв. Тухайлбал, УААА, соёлыг хөгжүүлэх тавдугаар таван жилийн төлөвлөгөөний хөрөнгө оруулалтын 35-аас доошгүй хувийг ХАА-н материал техникийн баазыг бэхжүүлэхэд зориулахаар төлөвлөжээ. 1971-1975 онуудад ХАА-д 1,9 миллиард төгрөгийн хөрөнгө оруулснаас 70 хувийг нь мал аж ахуйн үйлдвэрлэлийг бэхжүүлэхэд, үлдсэн хувийг нь газар тариалангийн үйлдвэрлэлд зориулжээ. Энэхүү ХАА-д оруулсан хөрөнгө оруулалт өмнөх таван жилийн хөрөнгө оруулалтаас 40 хувиар нэмэгдсэн байна.

Дээрх жилүүдэд ХАА-д нийлүүлсэн трактор 1,8 дахин, автомашин 10 хувиар, автомашин болон тракторын чиргүүл 15 хувиар нэмэгджээ. Үүний үр дүнд, нэг САА-д дунджаар 240 трактор (15 морины хүчинд шилжүүлснээр), 45 комбайн, 33 автомашин, нэг нэгдэлд 28 трактор, 13 автомашин зэрэг техник ногдох болжээ. 1971, 1973, 1974 онд мах, сүү, арьс шир, хонь, тэмээний ноос, ямааны ноолуур болон мал аж ахуйн бусад төрлийн бүтээгдхүүний бэлтгэлийн үнийг нилээд нэмэгдүүлж, янз бүрийн тракторын үнийг 17-33 хувь хүртэл, дизелийн түлш, бензиний үнийг 40-50 хувь хямдруулсан байна. 1976 оны байдлаар 259 ХААН, 45 САА, түүний дотор ТАА 11 болжээ. ХАА-н нэг нэгдэлд дунджаар 452 мянган га газар, нийгмийн 69 мянган мал ногдож байв. САА-д дунджаар 11 мянган га тариалангийн газар, 36 мянган мал ногдож байв⁶.

БНМАУ-ын УААА-ын салбаруудын ажилчин албан хаагчдын тоо өсөн нэмэгдэж, 1975 онд бүх ажилчид албан хаагчидын тоо 246,3 мянган хүн, түүнээс хөдөө аж ахуйн салбарт ажиллагсад 24,9 мянгад хүрч байв. Эдгээр ажиллагсадын

⁵ Хэнтий аймгийн архивын тасаг. Х-235.Д-1. ХН-11, 73.

⁶ МАХН-ын XVII их хурал.Дэлгэрэнгүй тайлан. Улаанбаатар: УХГ, 1976, 37.

66,9 мянган дээд, тусгай мэргэжлийн боловсролтойгоос 28,6 мянган дээд боловсролтой, 38,3 мянган нь тусгай мэргэжлийн дунд боловсролтой байжээ⁷.

Хэдийгээр дээрх бүх тоон үзүүлэлт, статистикийн тоо баримтад газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг гол байгууллага САА-дын тоо, түүний техник хангамж, боловсон хүчин материалаг бааз өсөн нэмэгдэж байсан хэдий ч энэ нь хөдөө аж ахуйд улсаас оруулсан хөрөнгө оруулалт, техник тоног төхөөрөмж, санхүүгийн дэмжлэгийн үр дүнд харагдаж буй тоон үзүүлэлт байв. Тиймээс ХАА-н салбарын тэр дундаа газар тариалангийн үйлдвэрлэлийн үзүүлэлт ерөнхий дүнгээрээ өссөн мэт харагдаж байгаа боловч бодит байдал дээр нэг га-аас авч байгаа үр тарианы өөрийн өртөг буураагүй, нэг га-гаас хураан авах ургацын хэмжээ ч бага байжээ. Атар газар нэмж хагалаагүй хэдий ч энэ үед ХАА-д оруулсан хөрөнгө оруулалт, боловсон хүчин, техник хангамж, цахилгаан хангамж илт өссөөр байхад нэг га авах ургацын хэмжээ нэмэгдэхгүй байв. 1971-1975 оны хооронд зарим үед улаан буудайн 1 га-гийн ургац 5цн байсан бөгөөд, энэ нь Эдийн засгийн харилцан туслах зөвлөлийн гишүүн орнуудтай харьцуулахад 2 дахин доогуур, төмснийх мөн адил, эрдэнэ шишийн ургац бусад оронтой харьцуулахад олон дахин бага байжээ⁸. Өөрөөр хэлбэл, Монголын газар тариаланд агротехникийн соёлыг нэвтрүүлэх бодит боломж бүрдсэн бөгөөд тариаланг химижүүлэх, усжуулах, хөрс судлалыг гүнзгийрүүлж, хамгаалах, техник тоног төхөөрөмжөөр хангах, услалтын системийн барилга байгууламжийг чанар сайтай барьж байгуулах, ашиглалтыг сайжруулах ажлыг хэрэгжүүлэх ХАА-н материаллаг баазын түвшин, боловсон хүчний хүрэлцээ, мэдлэг боловсрол, ажлын туршлага хангагдсан байв.

Түүнчлэн ХХ зууны хоёр дугаар хагасаас Монгол улсын хүн ам өсөж, 1960 онд 952,9 мянга байсан бол 1975 онд буюу 15 жилийн дотор 492,7 мянган хүнээр нэмэгдэж, 1445,6 мянгад хүрсэн байна. 1976 онд 1489,7 мянга⁹ болж, нэг жилийн дотор 44,1 мянган хүнээр нэмэгджээ. Хүн амд ноогдох ХАА-н бүтээгдэхүүнийг хоёр оноор (1960 он, 1975 он) харьцуулалт хийж үзвэл нэг хүн амд ногдох зарим бүтээгдэхүүний хэмжээ буурсан үзүүлэлт гарч байв. Тиймээс хүн амын гурил, будаа, төмс, хүнсний ногооны өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг аль болох дүүрэн хангаж, МАА-н тэжээлийн баазыг бэхжүүлэх зорилгоор атар газар эзэмших замаар тариалангийн талбайг өргөтгөж, ХАА-н таримал ургамлын ургацыг дээшлүүлэх үндсэн дээр газар тариалангийн бүтээгдэхүүнийг ихээхэн нэмэгдүүлэх, өсгөх шаардлага тавигдаж байв.

⁷ БНМАУ-ын УААА 1977 он. Улаанбаатар: УХГ, 1978, 56

⁸ Загасбалдан, Д. *БНМАУ дэлхийн эдийн засаг, соёлын хөгжилд*. Улаанбаатар: 1978, 135-136.

⁹ *БНМАУ-ын УААА 1976*. Улаанбаатар: 1977, 34.

Үүний дагуу 1976 оны 1-р сарын 29-нд хуралдсан МАХН-ын Төв хорооны XI бүгд хурал “Атар газар эзэмшиж тариалангийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх тухай” асуудал хэлэлцэж, атрын хоёрдугаар аяныг өрнүүлэх шийдвэр гаргаж, эх орны хүнс тэжээлийн өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг үндэслэн үр тариа, төмс ногоо, малын тэжээл үйлдвэрлэлтийг улам нэмэгдүүлэх зорилт тавьжээ. Тус бүгд хурал газар тариалангийн цаашдын зорилтыг тодорхойлж, улс ардын аж ахуй, соёлыг 1976-1980 онд хөгжүүлэх таван жилийн төлөвлөгөөнд тусган боловсруулах үйлдвэрүүдэд хөдөө аж ахуйн түүхий эдийг тасралтгүй нийлүүлэх, МАА-н тэжээлийн үйлдвэрийг нэмэгдүүлэх үүднээс VI таван жилд ЗХУ-ын тусламжтайгаар 230 мянган га атар нэмж эзэмших 11 аж ахуйг шинээр байгуулах зорилтыг дэвшүүлсэн байна. Дээрх тогтоолд атар газар эзэмшиж, тариалангийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх талаар үндсэн долоон зорилтыг дэвшүүлжээ.

Атрын анхны аян атар газрыг шинээр эзэмших замаар газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхийг зорьж байсан бол, хоёрдугаар аян

1-рт, тариалангийн талбайг нэмэгдүүлэх,

2-рт, нэг га-гаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэхийн тулд агротехникийн соёлын нэвтрүүлэх зорилтыг өмнөө тавьж байв. Үүний тулд тариалангийн талбайг өргөтгөхийн зэрэгцээ ХАА-н ургамлын га тутмаас авах ургацын нэмэгдүүлж, VI таван жилд үр тарианы нийт ургацын өсөлтийн 40 шахам хувь, төмс, хүнсний ногооны 50 хүртэл хувь, тэжээлийн ургамлын 60 орчим хувийг га-гаас авах ургацыг нэмэгдүүлэх замаар хангах зорилтыг дэвшүүлжээ. Судлаачдын тооцоолсноор ургацыг нэмэгдүүлэхэд:

-30 хувийг нь бордоо нэмэгдүүлнээс

-15 хувийг нь шинэ сортын үр хэрэглэснээр

-15 хувийг нь усалгаатай тариалснаар

-20 хувийг нь тариалж байсан ургацын бүтцийг өөрчилснөөр

-15 хувийг нь технологийг өөрчилснөөр тус тус нэмэгдүүлэх боломжтой ажээ. Тиймээс ХАА-н таримал ургамлын ургацыг ихээхэн нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн байгаль цаг уурын нөхцөлд тохирсон газар тариалангийн системийг боловсруулан нэвтрүүлэх, газар тариалангийн соёлжилтыг дээшлүүлэх, хөрсийг эвдрэлээс хамгаалах, газар тариаланг химижүүлэх, эрдэс бордоог ашиглах, ургамлын өвчин, хортонтой тэмцэхэд химийн аргыг өргөн хэрэглэх, үрийн аж ахуйн ажлыг эрс сайжруулж зөвхөн сортын үрээр тарьдаг болох, үр тарианы аж ахуйн хэрэгцээг хангахуйц хэмжээгээр элит үр үйлдвэрлэх ажлыг зохион байгуулах,

услалтын систем байгуулах, усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлэхийг зорьжээ. Үүний хамт газар тариалан хөгжүүлэхэд эрдэм шинжилгээний байгууллага, туршлага станцын үүрэг хариуцлагыг өндөржүүлж, тэдгээрийн хүчийг газар тариалангийн соёлжилтыг дээшлүүлж, ургацыг нэмэгдүүлэх зангилаа асуудлыг шийдвэрлэхэд чиглүүлэхийн дээр өндөр мэргэжилтэй боловсон хүчнээр хангаж, материаллаг баазыг нь сайжруулахаар заажээ.

Атрын хоёрдугаар аяныг өрнүүлж, газар тариаланг хөгжүүлснээр хүн амын хүнсний хэрэгцээгээ дотоодын үйлдвэрийн гурил, гурилан бүтээгдхүүнээр хангах том зорилтыг шийдвэрлэсэн төдийгүй, тус улсын ХАА-н бүтээгдхүүний үйлдвэрлэлийн эрс нэмэгдүүлжээ. Түүнчлэн газар тариалангийн салбар хөгжснөөр түүний дотоод бүтцэд чанарын өөрчлөлт гарч аж ахуйн шинэ төрлүүд (жимс, жимсгэний, зөгийн, малын тэжээлийн гэх мэт) бие даан хөгжиж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь тогтворжиж, шинжлэх ухаан техникийн ололтыг нэвтрүүлэх, эрчимжүүлэх боломж нэмэгдсэн байна. Газар тариалангийн үйлдвэрлэл нь тус улсад хүнсний үйлдвэрлэлийн олон төрөл хөгжих боломж нөхцлийг бодиттойгоор өргөтгөжээ. Атрын хоёрдугаар аян, түүний гол үр дүн нь газар тариалангийн үйлдвэрлэл, тогтвортой хөдөө аж ахуйн бие даасан, механикжсан салбар болж, хөдөөгийн нүүр царай шинэчлэгдэн хөгжсөн оршино.

Атрын хоёрдугаар аяныг тухайн цаг үе “Атрыг эзэмшсэн нь нам, ард түмний гавъяа”, “Энэ бүхэн БНМАУ-ыг Хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн орноос-Аж үйлдвэр, хөдөө аж ахуйн орон болгох намын программчилсан зорилтыг хэрэгжүүлэх үйлсэд хийсэн чухал алхам мөн” хэмээн үнэлж байсан нь оргүй зүйл биш юм. Ерөөс XX зуунд өрнөсөн атрын аянууд төдийгүй, 1990 оноос хойш буюу зах зээлийн системд шилжсэн үед 2008-2010 онуудад явагдсан “Атрын аян-3” ч төрийн тусламж дэмжлэг, тусгай хөтөлбөр, санхүүжилтийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж үр дүнд хүрсэн байдаг.

Abstract: There were three Virgin Lands Campaigns in Mongolia. The two of them were organized in the periods of the socialism material technique basis in the second half of the XX century. The first two Virgin Lands Campaigns were managed by Mongolian national revolutionary party and called and intensified by Mongolian revolutionary youth union and were performed by Collective farms. The first Virgin Lands Campaign was organized from 1959 to 1961 with the direct participation of the Soviet Union specialists and its machinery and power getting its goal and developed as agriculture, an independent rural economy branch. The second Virgin Lands Campaign was organized by Mongolians independently from 1976 to 1980 to meet the increasing demand of population, strengthen the livestock

breeding with cattle forage in the way of arable area extending, increasing agriculture cropper harvest reaching their goal successfully.

Ном зүй

1. *БНМАУ-ын нийгмийн бүтэц*. Улаанбаатар: 1984.
2. *БНМАУ-ын УААА 1976 он*. Улаанбаатар: 1977.
3. *БНМАУ-ын УААА 1977 он*. Улаанбаатар: УХГ, 1978.
4. Загасбалдан, Д. *БНМАУ дэлхийн эдийн засаг, соёлын хөгжилд*. Улаанбаатар: 1978.
5. *МАХН-ын XIV их хурал. Дэлгэрэнгүй тайлан*. Улаанбаатар: УХХЭХ, 1961.
6. *МАХН-ын XVII их хурал. Дэлгэрэнгүй тайлан*. Улаанбаатар: УХГ, 1976, 37.
7. *МАХН-ын Их хурал, ТХ-ны бүгд хурлуудын тогтоол шийдвэр. III хэсэг. 1957-1962*. Улаанбаатар: 1963.
8. *Монгол-Зөвлөлтийн харилцаа 1921-1974*. Хоёрдугаар боть. Нэгдүгээр хэсэг. Улаанбаатар: 1981.
9. Хэнтий аймгийн архивын тасаг. Х-235.Д-1. ХН-11, 73.